ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 213

танай ______________-ы № __________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ОДОНЧИМЭГ ТАНАА

Танай байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг зөвлөмжийн хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү..

Хавсралт .... хуудас

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

023030225

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галшар сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХЭА-2022/50/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2022 он | Аудитын газрын Дарга,<br>тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар<br>Утас: 70562112<br><br>Аудитын менежер: Д.Оюунтуяа<br>Утас: 99775390<br><br>Аудитор: Х.Еркегүл<br>Утас: 99040705 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ..... 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
3. Аудитын тайлан ..... 9
3.1 Ерөнхий зүйл ..... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 9
3.4 Материаллаг байдал ..... 9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 12
3.8 Аудитын гол асуудал ..... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 12
4. Аудитын илрүүлэлт ..... 13
4.2.1 Залруулсан алдаа ..... 13
4.2.2 Зөвлөмж ..... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 14

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 42

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М. ОДОНЧИМЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/A4 20220309

023033406

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **26,520,038.41** | **175,468,611.94** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | **52,878.40** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 52,878.40 |
| **3121** | **Төгрөг** | - | 52,878.40 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 26,206.40 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | 26,672.00 |
| **33** | **АВЛАГА** | - | **114,198,400.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 114,198,400.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **26,520,038.41** | **61,217,333.54** |
| **351** | **Түүхий эд материал** | 10,837,687.41 | 36,402,222.57 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,624,072.20 | - |
| 35130 | Эм боох материал | 7,213,615.21 | 36,402,222.57 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,682,351.00 | 24,815,110.97 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,811,400.00 | 2,115,860.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,175,617.00 | 13,922,051.97 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 387,200.00 | 1,935,700.00 |
| 35460 | Хүнсний материал | 599,865.00 | 954,230.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,708,269.00 | 5,887,269.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **587,356,075.62** | **600,455,843.64** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 587,356,075.62 | 600,455,843.64 |
| **392** | **Биет хөрөнгө** | 578,898,325.62 | 592,073,093.64 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 439,835,127.00 | 489,180,570.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (39,311,428.02) | (54,258,845.82) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 75,037,500.00 | 48,037,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (11,980,327.12) | (16,518,929.82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 137,613,492.97 | 155,524,485.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (59,131,662.99) | (67,697,872.52) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,358,829.10 | 34,903,710.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,550,225.28) | (12,903,163.39) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 9,213,800.00 | 9,213,800.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (921,380.04) | (1,842,760.08) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,088,982.00 | 8,788,982.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (354,382.00) | (354,382.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,457,750.00 | 8,382,750.00 |
| 39301 | Програм хангамж | 367,000.00 | 367,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (173,250.00) | (248,250.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,264,000.00 | 8,264,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **613,876,114.03** | **775,924,455.58** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | **9,802,398.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 9,802,398.00 |
| **413** | **Өглөг** | - | 9,802,398.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 9,802,398.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 9,802,398.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **613,876,114.03** | **766,122,057.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 613,876,114.03 | 766,122,057.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 293,129,843.94 | 293,129,843.94 |
| 51101 | Өмч: - төрийн | 293,129,843.94 | 293,129,843.94 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 281,175,978.78 | 433,421,922.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 281,175,978.78 | 281,175,978.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 152,245,943.55 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 39,570,291.31 | 39,570,291.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **613,876,114.03** | **775,924,455.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **505,824,239.50** | **755,363,858.53** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **140,703,865.50** | **100,074,683.53** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 140,703,865.50 | 100,074,683.53 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 140,703,865.50 | 100,074,683.53 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,933,282.00 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 121,770,583.50 | 100,074,683.53 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **365,120,374.00** | **655,289,175.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсөөс | 293,933,900.00 | 368,036,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 293,933,900.00 | 368,036,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **35,782,214.00** | **248,444,595.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,010,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 72,600.00 | 240,336,295.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 32,699,614.00 | 8,108,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **12,720,000.00** | **25,108,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,720,000.00 | 25,108,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **22,684,260.00** | **13,699,980.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,684,260.00 | 13,699,980.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **423,803,309.13** | **581,596,278.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **423,803,309.13** | **581,596,278.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **423,240,985.84** | **557,611,660.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **238,759,382.00** | **303,815,725.00** |
| 210101 | Үндсэн цалин | 194,307,454.00 | 176,149,705.00 |
| 210102 | Нэмэгдэл | 28,150,751.00 | 103,611,639.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 525,068.00 | - |
| 210104 | Урамшуулал | 15,776,109.00 | 24,054,381.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,762,479.16** | **39,986,324.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,157,352.16 | 29,479,104.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,082,220.00 | 2,677,114.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,303,151.00 | 2,141,892.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 373,850.00 | 517,063.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,845,906.00 | 5,171,148.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **11,465,726.55** | **22,303,080.29** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,890,726.55 | 2,297,457.29 |
| 210302 | Түлш, халаалт | 8,560,000.00 | 19,647,623.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,000.00 | 358,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **20,782,929.32** | **25,650,432.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,107,593.00 | 3,127,940.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,595,436.32 | 17,403,992.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 819,500.00 | 1,024,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 260,400.00 | 2,595,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,498,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **63,447,482.52** | **104,164,602.44** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 43,341,672.52 | 94,507,422.44 |
| 210502 | Хоол, хүнс | 9,395,356.00 | 8,221,780.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,710,454.00 | 1,435,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,435,026.00** | **2,612,750.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 300,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 6,135,026.00 | 2,612,750.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,469,000.00** | **2,322,314.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,469,000.00 | 2,322,314.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,896,546.00** | **754,374.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,447,846.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 152,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 22,250.00 | 95,927.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 8,085.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,000.00 | 66,112.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **39,222,414.29** | **56,002,059.25** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,994,640.00 | 4,122,114.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 36,227,774.29 | 51,879,945.25 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 562,323.29 | 23,984,617.71 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **420,000.00** | **23,240,190.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 420,000.00 | 23,240,190.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **142,323.29** | **744,427.71** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 142,323.29 | 744,427.71 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 82,020,930.37 | 173,767,579.84 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | **21,521,636.29** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 21,521,636.29 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | **(21,521,636.29)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **82,020,930.37** | **152,245,943.55** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | - | - | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - | - |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **293,129,843.94** | **39,570,291.31** | **281,175,978.78** | - | **613,876,114.03** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | - | - | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 152,245,943.35 | | 152,245,943.35 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **293,129,843.94** | **39,570,291.31** | **433,421,922.33** | - | **766,122,057.58** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **365,753,656.00** | **541,090,775.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **633,282.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 633,282.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 633,282.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 633,282.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **365,120,374.00** | **541,090,775.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсөөс** | 293,933,900.00 | 368,036,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 293,933,900.00 | 368,036,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **35,782,214.00** | **134,246,195.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,010,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 72,600.00 | 126,137,895.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 32,699,614.00 | 8,108,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 12,720,000.00 | 25,108,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,720,000.00 | 25,108,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 22,684,260.00 | 13,699,980.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,684,260.00 | 13,699,980.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **365,120,374.00** | **536,087,896.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **365,120,374.00** | **536,087,896.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **364,558,050.71** | **511,943,468.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 234,713,330.00 | 303,809,183.00 |
| 210101 | Үндсэн цалин | 161,498,936.00 | 150,320,538.00 |
| 210102 | Нэмэгдэл | 53,549,500.00 | 125,287,745.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,752,000.00 | 3,606,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,912,894.00 | 24,594,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,896,470.16 | 39,982,499.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,265,033.16 | 29,475,279.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,082,220.00 | 2,677,114.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,749,861.00 | 2,141,892.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 373,850.00 | 517,063.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,425,506.00 | 5,171,148.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,631,726.55 | 20,717,072.29 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,890,726.55 | 2,227,057.29 |
| 210302 | Түлш, халаалт | 8,560,000.00 | 18,132,015.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 181,000.00 | 358,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,450,100.00 | 23,541,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,650,000.00 | 2,778,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,918,100.00 | 15,321,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,032,000.00 | 1,059,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,000.00 | 1,790,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,500,000.00 | 2,590,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 42,309,304.00 | 92,161,780.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 32,272,304.00 | 80,828,980.60 |
| 210502 | Хоол, хүнс | 7,411,000.00 | 8,358,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,626,000.00 | 2,974,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,238,000.00 | 5,224,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 50,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,238,000.00 | 5,174,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,469,000.00 | 2,184,314.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,469,000.00 | 2,184,314.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,000,600.00 | 754,374.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,551,900.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 57,950.00 | 152,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 18,750.00 | 104,012.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 15,000.00 | 66,112.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,849,520.00 | 23,569,196.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,849,520.00 | 23,569,196.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **562,323.29** | **24,144,427.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 420,000.00 | 23,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 420,000.00 | 23,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 16,091.45 | 744,427.71 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,091.45 | 744,427.71 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 126,231.84 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 126,231.84 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **633,282.00** | **5,002,878.40** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **4,950,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **4,950,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 4,950,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 4,950,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(4,950,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 633,282.00 | 52,878.40 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 52,878.40 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **415,726,300.00** | **406,073,945.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 415,726,300.00 | 406,073,945.89 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 414,726,300.00 | 405,073,945.89 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 281,126,100.00 | 279,417,201.00 |
| 210101 | Үндсэн цалин | 163,966,100.00 | 125,928,556.00 |
| 210102 | Нэмэгдэл | 87,525,100.00 | 125,287,745.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,040,000.00 | 3,606,000.00 |
| 210104 | Урамшуулал | 24,594,900.00 | 24,594,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **37,796,700.00** | **36,551,108.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,172,500.00 | 26,043,888.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,656,000.00 | 2,677,114.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,124,900.00 | 2,141,892.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 531,200.00 | 517,063.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,312,100.00 | 5,171,148.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,450,800.00** | **20,717,072.29** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,960,500.00 | 2,227,057.29 |
| 210302 | Түлш, халаалт | 18,108,100.00 | 18,132,015.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 382,200.00 | 358,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,013,700.00** | **22,109,750.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,200,000.00 | 2,778,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,425,100.00 | 14,425,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 1,059,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,438,600.00 | 1,790,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,450,000.00 | 2,056,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **27,954,300.00** | **25,765,540.60** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 14,954,300.00 | 14,935,240.60 |
| 210502 | Хоол, хүнс | 9,000,000.00 | 8,358,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,000,000.00 | 2,471,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,657,700.00** | **8,647,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,657,700.00 | 3,647,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,800,000.00 | 1,751,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,800,000.00 | 1,751,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,026,000.00** | **754,374.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 152,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 104,012.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 100,000.00 | 66,112.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,901,000.00** | **9,360,900.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,901,000.00 | 9,360,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **415,726,300.00** | **406,100,152.29** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **368,036,100.00** | **368,036,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 368,036,100.00 | 368,036,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **25,108,500.00** | **24,364,072.29** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 25,108,500.00 | 24,364,072.29 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮ** | **22,581,700.00** | **13,699,980.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,581,700.00 | 13,699,980.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **26,206.40** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - |
| 610001 | Төсвийн байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21.00 | 21.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 16.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | - | - |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **134,219,523.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **134,219,523.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **111,819,523.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **24,391,982.00** |
| 210101 | Үндсэн цалин | 24,391,982.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,431,391.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,431,391.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,431,300.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 896,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 534,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **66,396,240.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 65,893,740.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 502,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,527,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,527,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **433,314.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 433,314.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,208,296.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,208,296.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,400,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,400,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **134,246,195.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **134,246,195.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 126,137,895.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,108,300.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **26,672.00** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галшар сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Галшар сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сумын ЭМТ нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галшар сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 423.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Галшар сумын ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 451.7 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материалын данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 52.9 | 52.9 |
| Авлага | - | 114,198.4 | 114,198.4 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 26,520.0 | 61,217.3 | 34,697.3 |
| Үндсэн хөрөнгө | 587,356.1 | 600,455.8 | 13,099.8 |
| **Нийт хөрөнгө** | **613,876.1** | **775,924.5** | **162,048.3** |
| Өр төлбөр | - | 9,802.4 | 9,802.4 |
| Засгийн газрын сан /Орон нутгийн сан | 293,129.8 | 293,129.8 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 281,176.0 | 281,176.0 | - |
| Тайлант оны үр дүн | | 152,245.9 | 152,245.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 39,570.3 | 39,570.3 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **613,876.1** | **775,924.5** | **162,048.3** |
| **Нийт орлого /Үр дүнгийн тайлан** | **505,824.2** | **755,363.9** | **249,539.6** |
| **Нийт зардал /Үр дүнгийн тайлан** | **423,241.0** | **581,596.3** | **158,355.3** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 114.2 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 61.2 сая төгрөг болж 34.7 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь короновируст халдварын үед хэрэглэх эм, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 600.4 сая төгрөг болж 13.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 81.5 сая төгрөг, батлагдсан төсвөөс 4.9 сая төгрөг, нийт 86.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 37.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн акталж данснаас хассан байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 293.1 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 755.4 сая төгрөг болж, өмнөх оноос 249.5 сая төгрөгөөр буюу 49.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид-19 халдварт өвчний эмчилгээний зардлын санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 581.6 сая төгрөг болж, өмнөх оноос 158.3 сая төгрөгөөр буюу 37.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нормативт зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Энэ нь короновирусt халдварын дэгдэлттэй холбоотой илүү цагийн хөлс, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, төвийн халаалтын системд холбогдсонтой холбоотой тогтмол зардал өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд орон нутгийн төсвөөс 25.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 22.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 368.0 сая төгрөг, нийт 415.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээс 368.0 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 13.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 25.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 406.1 сая төгрөгийг зарцуулжээ. Төсвийн гүйцэтгэл 97.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМДС-аас короновирусt халдвараар гэрийн хяналт болон тусгаарлах байрны хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилт 82.9 сая төгрөг, дархлаажуулалтын вакцины санхүүжилт 13.8 сая төгрөг, эрүүл мэндийн ажиллагсдад олгох нэг удаагийн тэтгэмжийн санхүүжилт 22.4 сая төгрөг, эргэлтийн эмийн сангийн хөнгөлөлттэй эмийн санхүүжилт 7.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8.1 сая төгрөг, нийт 134.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитаар анхаарах гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 116.1 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, зарлагын 42.5 сая төгрөгийн 5 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 56.5 сая төгрөгийн 4 мэдээлэл, 4 улирлын төсвийн гүйцэтгэл зэрэг нийт 215.1 сая төгрөгийн 15 мэдээллийг мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал бүртгэгдээгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 241.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 26.1 сая төгрөгийн алдааг залруулж, 215.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг 26.1 сая төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.

### 4.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

***Илрүүлэлт:***

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 116.1 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, зарлагын 42.5 сая төгрөгийн 5 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 56.5 сая төгрөгийн 4 мэдээлэл, 4 улирлын төсвийн гүйцэтгэл зэрэг нийт 215.1 сая төгрөгийн 15 мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

***Өгсөн зөвлөмж:***

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан зарчмыг баримтлан шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Галшар сумын Эрүүл мэндийн төв | 1 | 26.1 | 1 | 26.1 | | | | | | |
| Дүн | | 1 | 26.1 | 1 | 26.1 | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Галшар сумын Эрүүл мэндийн төв | 1 | 216.1 | | | | | | | 1 | 216.1 |
| Дүн | | 1 | 216.1 | | | | | | | 1 | 216.1 |
| **Нийт дүн** | | **2** | **241.2** | **1** | **26.1** | | | | | **1** | **216.1** |